

Орхон аймгийн Баян-Өндөр суманд хийсэн шалгалтын товч тайлан

Шалгалтанд нийт 29 үйлчилгээ эрхлэгч хамрагласанаас тусгай зөвшөөрлийн дагуу радио давтамжийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа нь телевизийн өргөн нэвтрүүлгийн 7, Утасгүй агаарын олон сувгийн телевизийн үйлчилгээ эрхлэх 3, радио өргөн нэвтрүүлгийн 8, ISP утасгүй интернэт үйлчилгээ үзүүлэгч 1, нийт 19 тусгай зөвшөөрөл эзэмшигчид байсан. Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулаагүй байсан болно. Тус сумын хувьд нэвтрүүлэгч болон нэвтрүүлэх антенуудаа бүгд МХС ХХК-ийн эзэмшлийн радио релейний 163-р станц дээр байрлуулан үйл ажиллагаагаа явуулж байлаа.

Радио өргөн нэвтрүүлэг

Нийт 13 үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага, компаниудаас Ауразон ХХК радио ФМ-89.9, Монгол оросын хамтарсан эрдэнэт үйлдвэр ФМ-101.9, Эрдэнэсүврэй ХХК ФМ-103.1, Номин макс ХХК ФМ-104.5, Бунадо ХХК ФМ-105.1, Радио телевизийн сүлжээ УТҮГазар ФМ-105.5, Мөнхийн үйлс саруул ХХК ФМ-106.5, Монгол оросын хамтарсан эрдэнэт үйлдвэр ФМ-107.1 гэх нийт 8 радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байсан болно. Эрдэнэт Лайт ХХК ФМ-100.8, Ч.Амаржаргал ФМ-101.4, Агаарын Суваг ХХК ФМ-102.4, Фило ХХК ФМ-105.7, Эрдэнэтийн Гүүшүүд ТББ ФМ-107.6 гэх эдгээр компаниуд өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа явуулаагүй байлаа.

Ауразон ХХК радио ФМ-89.9, Монгол оросын хамтарсан эрдэнэт үйлдвэр ФМ-101.9 ба ФМ-107.1, Номин макс ХХК ФМ-104.5, Бунадо ХХК ФМ-105.1 эдгээр компаниудын нэвтрүүлэх станцын үйл ажиллагаа хэвийн сайн явагдаж байсан болно. Эрдэнэсүврэй ХХК ФМ-103.1-ийн хувьд 99.7МГц болон 99.1МГц давтамж дээр хажуугийн цацаргалт үүсгэж байлаа. Радио телевизийн сүлжээ УТҮГазар ФМ-105.5-ийн нэвтрүүлэх станцын марк өөрчлөгдсөн. Мөнхийн үйлс саруул ХХК ФМ-106.5 чадал тусгай зөвшөөрөлд зааснаар 500 Вт байхаас 139.3 Вт хэмжигдэж, чадал багассан зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн болно.

Телевизийн өргөн нэвтрүүлэг

Тус шалгалтаар Монгол оросын хамтарсан эрдэнэт үйлдвэр телевиз /6-р суваг/, Лха ХХК 8-р суваг, Фило ХХК-ийн 10-р сувгийн телевиз, Эрдэнэт Таймс Сонин 12-р сувгийн телевиз гэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нар үйл ажиллагаа явуулаагүй болох нь хэмжилт шалгалтаар тогтоогдсон. Эрдэнэт Лайт ХХК 32-р сувгийн телевиз нь үйл ажиллагаа явуулж буй боловч тусгай зөвшөөрөлд зааснаар нэвтрүүлэгчийн гаралтын чадал 1000 Вт байхаас 132 Вт гаралтын чадалтай байсан. Номин Макс 12-р сувгийн телевиз, Ишилан ХХК 37-р сувгийн телевиз, ГДТХ ХХК 24-р сувгийн телевизүүдийн үйл ажиллагаа хэвийн сайн явагдаж байлаа. Бунадо ХХК 30-р сувгийн телевизийн хувьд гаралтын чадал багассан, Асгалтын Гол ХХК 35-р сувгийн телевизийн хувьд нэвтрүүлэх станцын марк өөрчлөгдсөн зэрэг зөрчил дутагдалтай үйл ажиллагаагаа явуулж байсан болно.

РТС УТҮГ Олон сувгийн телевиз нь телевизийн 39, 41, 43, 45, 47, 49, 51, 53-р сувгийн модулятор дээр тохируулан 8 сувгаар телевизийн нэвтрүүлэг цацан, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байлаа.

Телевизийн олон сувгийг дамжуулах MMDS үйлчилгээ

Тус үйлчилгээг 3 байгууллага эрхэлж байлаа. Дархан ширхэнцэг ЗГБХН нь телевизийн олон сувгийг түгээх үйлчилгээндээ тусгай зөвшөөрлөөр олгогдсон 2.2ГГц-2.3ГГц зурвасаас 50МГц-ээр хэтэрсэн, Тэнгэрийн ауруг ХХК нь телевизийн олон сувгийг түгээх үйлчилгээндээ тусгай зөвшөөрлөөр олгогдсон 2.8ГГц-2.848ГГц зурвасаас 12МГц-ээр хэтэрсэн зэрэг зөрчилүүд илэрсэн байна. Агаарын суваг ХХК нь радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн дагуу 20 Вт-ын

гаралтын чадалтай нэвтрүүлэгч ашиглан 2500-2700 МГц-ын давтамж дээр нь үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байлаа.

Утасгүй интернэтийн WIFI-ийн хэмжилт

Тус үйлчилгээг эрхлэгч Агаарын суваг ХХК-ийн WiFi төхөөрөмж нийт 22 ширхэг төхөөрөмж бүртгэгдсэн бөгөөд Тэнгэрийн ауруг ХХК гэх тусгай зөвшөөрөлтэй компани тус суманд үйл ажиллагаа явуулаагүй байсан болно.

Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдэд хийсэн хэмжилт

Үүрэн холбооны Мобиком корпораци ХХК, Юнител групп ХХК, Скайтел ХХК, Жи-Мобайл ХХК оператор компаниудын тусгай зөвшөөрлийн радио давтамжуудад гадны харилцан нөлөөлөл илрээгүй бөгөөд давтамж ашиглалт хэвийн байв.